



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 29 өдөр

Дугаар А/557

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "а", 29.1.6-ын "а", Төсвийн тухай хуулийн 14.2.3.заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11.1.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны ээлжит XI хуралдааны 05 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Хөвсгөл аймгийн Жаргалант сумын 5 дугаар багийн Зорилтот өрхийн эмэгтэй Базаррагчаа овогтой Эрэвгийлхам нь 2020 оны 10 дугаар сарын 27-ны өдөр биеийн байдал хүндэрч, сумаасаа аймгийн Нэгдсэн эмнэлэгт яаралтайгаар хүргэгдэн ирж Тархины аалзан ясны цус харвалт гэж оношлогдож улмаар эхийн амь насыг яаралтай аврах зорилгоор Улсын төв гуравдугаар эмнэлэгт хүргүүлэхэд шаардлагатай байгаа эмчлүүлэгч болон эмчийн замын зардалд 682600 (Зургаан зуун наян хоёр мянга зургаа зуун) төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх хөрөнгийг "Эрүүл иргэн-Эрхэм баялаг" дэд хөтөлбөрийн "Эх хүүхдийн эрсдэлийн сан"-гийн зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Базар), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Э.Аззаяа) нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Ган-Очир)-д даалгасугай.

ДАРГА

Л.ГАНБОЛД